



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу
хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ



*Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээнүүдийг УТХО-ын
төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж байна.*

Сүхбаатар сум
2021 оны 04 дүгээр сар

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт
Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд,
Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?
Аудитын менежер Б.Батмөнх	1.1 Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн, шинээр эхлэх төсөл арга хэмжээний 67.3 хувь нь “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Сэлэнгэ аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй уялдаагүй байна.
Ахлах аудитор С.Баасансүрэн	1.2 Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 70.9 хувийн зураг, төсвийг хууль батлагдсанаас хойш гүйцэтгүүлсэн бол зураг, төсвийн 68.9 хувийг магадлал хийлгэж баталгаажуулаагүй байна.
Аудитор Ж.Цогт	1.3 Он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн дагуу жигд хуваарилаагүй байна.
2021 он	2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70363036 дугаарын утас, Selenge@audit.gov.mn цахим сайтаар харилцана уу.	2.1 “Инженерийн шугам сүлжээ”-г худалдан авах ажиллагаанд Билиг ДБ сургуульд чиглэсэн шалгуурыг тусгасан нь худалдан авах ажиллагааны өрсөлдөх тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй байх үндсэн зарчмыг алдагдуулсан байна. 2.2 Тайлант онд 5 төсөл, арга хэмжээ гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй байна. 2.3 УТХО-ын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт огт хийгдээгүй байна. 2.4 Гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 5 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 171.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.
ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд	Илрүүлсэн зөрчил Дүгнэлт Зөвлөмж Судалгаа 1-4 Хавсралт 7

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЭА	Сэлэнгэ аймаг
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ШТА	Шууд тайлагнах аудит

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- **Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх?**
- **Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх?**

Хамрах хүрээ:

Аудитад улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлсэн хөрөнгө, оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг аймгийн ТЭЗ, ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнууд, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт шалгалт, худалдан авах ажиллагааны болон санхүүжилтийн баримт материалуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан, аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Орон нутгийн өмчийн газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, мэдээ, шаардлагатай бусад баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “*Барилгын ажлын захиалагчийн дүрэм*”, 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “*Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм*”, 317 дугаар тогтоолоор баталсан “*Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм*”, 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “*Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр*”, Сангийн

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”, 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”, 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”, 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав.

Үндсэн мэдээлэл:

2020 оны төсвийн тухай хуулиар Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 86,690.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 76 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас он дамжин хэрэгжих 58,788.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээ, тайлант онд шинээр хэрэгжих 27,901.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 56 төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн ТЕЗ-д он дамжсан 6, шинээр эхлэх 55 зэрэг нийт 61 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлснээс 53 төсөл, арга хэмжээнд 55,166.3 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.

Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээнээс тайлант онд 39 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихээс 34 төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар хүлээн авсан бол 5 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт нар 2020 оны 3 дугаар сарын 20-оос 4 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн, шинээр эхлэх төсөл арга хэмжээний 67.3 хувь нь “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Сэлэнгэ аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй уялдаагүй байна.

1.1.1 2020 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт ЗГХЭГ болон 6 яаманд харьяалагдах 86,690.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 76 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав /

1.1.2 Үүнээс 57,807.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 56 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав /

1.1.3 2020 оны Төсвийн тухай хуульд БСШУС-ын / тухайн үеийн нэрээр / сайдын багцад тусгагдаж, батлагдсан төсөл, арга хэмжээнээс 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 1а/734 дүгээр албан бичгээр 238.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ, 02 дугаар сарын 21-ний өдрийн А/96 дугаар тушаалаар 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав./

1.1.4 Ингэснээр тайлант онд аймгийн Засаг даргад нийт 58,063.5 сая төгрөгийн 61 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрх шилжиж ирснээс 35,240.1 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос он дамжсан, 22,823.4 сая төгрөгийн 55 нь төсөл, арга хэмжээ нь шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав /

1.1.5 Сэлэнгэ аймгийн Засаг даргаас УТХО-ын 2020 оны төлөвлөгөөнд тусгуулахаар ЗГХЭГ-т 1,715.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, БСШУСЯ, БХБЯ, ЭМЯ-дад 57,097.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 69 зэрэг нийт 71 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.

1.1.6 Тайлант онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн шинээр эхлэх 22,823.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээнээс санал хүргүүлсэн 4,837.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ нь төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1 /сая төгрөгөөр/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Аймгаас санал хүргүүлсэн, төсөл, арга хэмжээ		Төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан төсөл арга хэмжээ		2020 онд шинээр эхлэх, эрх шилжүүлсэн нийт төсөл, арга хэмжээ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Барилга, хот байгуулалтын сайд	3	8,437.9			12	3,278.6

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

2	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	58	43,853.1	14	3,854.9	28	7,806.3
3	Зам тээвэр хөгжлийн сайд					4	8,374.0
4	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	2	1,715.2	1	700.0	1	700.0
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд					1	500.0
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд					4	1,548.0
7	Эрүүл мэндийн сайд	8	4,806.4	3	282.1	5	616.3
Нийт		71	58,812.6	18	4,837.0	55	22,823.2

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-аас яамдад хүргүүлсэн санал, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль

1.1.7 Дээрхээс үзэхэд аймгийн Засаг даргаас хүргүүлсэн саналд тусгагдаагүй 17,986.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан буюу өөрөөр хэлбэл аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн, шинээр эхлэх төсөл арга хэмжээний 67,3 хувь нь “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Сэлэнгэ аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй уялдаагүй байна.

1.1.8 Аймгийн ТЭЗ-аас санал хүргүүлж, батлагдсан 18 төсөл, арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 258.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 583.0 сая төгрөгөөр бууруулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2 /сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Батлагдсан төсөвт өртөг	ТЭЗ-ийн саналд тусгагдсан өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	
					Нэмэгдсэн	Хасагдсан
1	IV.1.37	Засаг даргын Тамгын газрын барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	700.0	715.2		15.2
2	XII.1.2.14	Сургуулийн байрын цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн шугам сүлжээний их засвар /Сэлэнгэ, Шаамар сум/	46.0	45.9	0.1	
3	XII.1.2.60	Сургуулийн хичээлийн байрын дотор сантехникийн их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	300.0	650.0		350.0
4	XII.1.2.63	Сургуулийн цайны газрын дээврийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 5 дугаар сургууль/	40.0	20.0	20.0	
5	XII.1.2.81	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг/	199.3	199.0	0.3	
6	XII.1.2.84	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 3 дугаар цэцэрлэг, "А" байр/	441.0	251.9	189.1	
7	XII.2.2.2	Мөнгөнхараа чуулгын байрын их засвар, тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Мандал сум/	1,200.0	1,189.7	10.3	
8	XII.5.1.4.48	Цэцэрлэгийн барилгын засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум 1 дүгээр цэцэрлэг /	45.0	56.8		11.8
9	XVII.1.65	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Сайхан сум/	120.0	81.0	39.0	
10	XVII.2.17	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Сэлэнгэ, Зүүнбүрэн сум/	84.0	175.0		91.0
11	XVII.2.18	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/	78.1	193.1		115.0
Нийт			3,253.4	3,577.6	258.8	583.0

1.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу?

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 70.9 хувийн зураг, төсвийг хууль батлагдсанаас хойш гүйцэтгүүлсэн бол зураг, төсвийн 68.9 хувийг магадлал хийлгэж баталгаажуулаагүй байна.

1.2.1 УТХО-ын төлөвлөгөөнд 2020 онд шинээр хэрэгжих 22,823.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээ батлагдсанаас шинж чанарын хувьд их засварын 34, барилга угсралтын 16, тавилга, тоног төхөөрөмж 3, инженерийн шугам сүлжээ худалдан авах 1, төсөл 1 байна.

1.2.2 Үүнээс их засварын 34, барилга угсралтын 13 зэрэг зураг, төсөл нь хийгдсэн байх шаардлагатай нийт 14,289.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 47 төсөл арга хэмжээний /тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 3, инженерийн шугам сүлжээ худалдан авах 1, “Шинэ хөдөө” төсөл 1, түлхүүр гардуулах нөхцөлтэй 3 төсөл арга хэмжээ хасагдаад / зураг, төсвийг гүйцэтгэгч байгууллагуудтай 985.4 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

1.2.3 Эдгээрээс 1,503.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний зураг төсвийг төсөл батлахаас өмнө хийсэн бол 12,726.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээний зураг төсвийг төсөл батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгүүлж, 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг зураг төсөвгүйгээр баталж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4⁴ дахь, Барилгын тухай хуулийн 24.1.1⁵ дэх, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3.2⁶ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-т харуулав./

1.2.4 Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.4⁷-т заасны дагуу зураг, төсөл зохиохын өмнө аймгийн ерөнхий архитектур нь архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулахаар зохицуулагдсан атал шинээр эхлэх 13 барилга угсралтын ажлаас дөнгөж 5 барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулж, баталсан байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 5-д харуулав./

1.2.5 Мөн уг журмын 3.5⁸ дахь заалтын дагуу шинээр эхлэх барилга угсралт, их засварын 47 төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵ Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 24.1.1.батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх.

⁶ Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай ТЭЗҮ, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна.

⁷ Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектур батална.

⁸ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

батлах ёстой атал 37 төсөл, арга хэмжээний зураг төслийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-т харуулав./

1.2.6 Инженер-геологийн дүгнэлтэд магадлал хийлгэх шаардлагатай эрх шилжүүлсэн гүүрний болон барилга угсралтын 3,830.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнээс 1,280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний инженер-геологийн дүгнэлтийг магадлалаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”, Барилгын тухай хуулийн 25.2 дахь “Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.4. инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-аас харах/

1.2.7 Эрх шилжүүлсэн УТХО-ын 22,823.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээнээс 45 төсөл, арга хэмжээ /“Түлхүүр гардуулах нөхцөл”-тэй 7,344.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, зураг төсөв огт хийгдээгүй 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, тоног төхөөрөмж, тавилга худалдан авах 3, төсөл 1, инженерийн шугам сүлжээ худалдан авах 1 төсөл, арга хэмжээнүүд хасагдаад/- ний зураг төсөлд магадлал хийлгэхээс 4,539.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээний зураг төсөлд магадлал хийлгэж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 25.2.1⁹, 25.2.5¹⁰, 25.5¹¹ дахь, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.3¹² дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 6-д харуулав./

1.2.8 Газрын зөвшөөрөл болон техникийн нөхцөл, инженер-геологийн дүгнэлтийг иж бүрэн хийлгээгүй шинээр эхлэх барилга байгууламжийн 3,830.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж, батлуулсан нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.2¹⁵ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 /сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Инженер-геологийн дүгнэлтийг магадлалаар баталгаажуулсан огноо	Газрын зөвшөөрөл олгосон огноо	Техникийн нөхцөл олгосон огноо			
			Эхлэх	Дуусах				Цахилгаан хангамж	Дулаан хангамж	Ус хангамж, ариутгах татуурга	Холбоо дохиолол
1	IV.1.37	Засаг даргын Тамгын газрын барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	2020	2020	700.0		Баруунбүрэн сумын Засаг даргын 2020.01.24-ний А/07 дугаар захирамж	2020.02.07 №21/20	2020.03.02 №01	2020.03.02 №01	2020.02.27 №02

⁹ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.1.газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн

10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт.

¹⁰ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5. энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

¹¹ Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.

¹² Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд магадлал хийнэ.

¹⁵ Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-д заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

2	Х.1.1.86	Орон сууцны дулааны шугам сүлжээ, 60 айл /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон, 6 дугаар баг/	2020	2021	150.0				Сэлэнгэ энерго ХХК 2020.04.29 №09		
3	Х.1.1.128	Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2020	2021	450.0	2019.03.25	Шаамар сумын Засаг даргын 2013.05.07-ны захирамж				
4	Х.1.1.148	Цэвэр усны шугам /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Хонгор морьт, 1 дүгээр баг/	2020	2021	400.0						
5	Х.1.1.1.289	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Ерөө сум/	2020	2021	2,100.0	Топ гео ХХК 2020.01.13 2020/13		ДСЦТС 2020.01.17 №39/39-2020-01	Монжим ХХК 2020.01.21	Урсгал ус ЖК 2020.01.23 №01	МХС ТӨХХК 2020.01.24 А-02
6	Х.1.1.2.1.19	Хүйтний голын тэмээ оломын гарамын бетон гүүр /Сэлэнгэ, Жавхлант сум/	2020	2020	30.0						
НИЙТ ДҮН					3,830.0	1,280.0	2,680.0	880.0			

1.2.9 Хувийн хэвшлийн санхүүжилтээр 2013-2014 онд ашиглалтад орсон, зураг төсвийг магадлал хийлгэж баталгаажуулаагүй, хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй 633.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Инженерийн шугам сүлжээ худалдан авах /Сэлэнгэ, Мандал сум, 6 дугаар баг/ төсөл, арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж, баталсан нь Барилгын тухай хуулийн 25.2.1²⁷, 25.2.5²⁸, 25.5²⁹ дахь, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.3³⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

1.2.10 Дээр дурдсанчлан зураг, төсөв хийгдээгүй, магадлалаар баталгаажуулаагүй, газрын зөвшөөрөл болон техникийн нөхцөл, инженер-геологийн дүгнэлтийг иж бүрэн хийгээгүй төсөл арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн нь ажлын явц удаашрах, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх, санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулсан уу?

Он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн дагуу жигд хуваарилаагүй байна.

1.3.1 УТХО-аар 2020 онд хэрэгжих төсөл, арга хэмжээнээс зураг төслийн даалгаврыг боловсруулаагүй, газрын зөвшөөрөлгүй, инженер-геологийн дүгнэлт гараагүй, техникийн нөхцөл олгогдоогүй буюу төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг Төсвийн хуульд тусгаж батлуулсан талаар тайлангийн 1.2 дугаар бүлэгт тодорхой дурдсан болно.

1.3.2 Сангийн яамнаас УТХО-ын үр ашгийг нэмэгдүүлэх, тавигдах хяналтыг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор УТХО-ын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn цахим хуудас болон гар утасны аппликейшныг ашиглалтад оруулсан бөгөөд уг цахим хуудсыг бүрэн ашигласнаар төсөл, арга

²⁷ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.1.газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт.

²⁸ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5. энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

²⁹ Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.

³⁰ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд магадлал хийнэ.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

хэмжээг төлөвлөлтөөс эхлэн улсын комисс хүлээн авах хүртэлх бүх үе шатны ажлыг хянан, удирдах боломжтой болсон байна.

1.3.3 Уг цахим системд ТЭЗҮ, зураг төсөв, санхүү, эдийн засгийн шинжилгээ, газрын зөвшөөрөл, инженер-геологийн дүгнэлт, техникийн нөхцөл, төслийн хураангуй мэдээлэл зэрэг төсөвлөлтийн шаардлагад тавигдах бүхий л материалыг бүрэн хавсаргаснаар дараагийн үе шатад шилжиж, Сангийн ямаар хянагдан баталгаажсанаар УТХО-ын жагсаалтад тусгагдахаар зохицуулагдсан байдаг.

1.3.4 Гэтэл УТХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн шинжилгээ, бусад холбогдох баримт материалыг бүрэн оруулж, хянуулалгүйгээр батлуулсан байгаа нь /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтнүүд, ГХБХБГ-ын Барилгын хэлтсийн дарга, БСУГ-ын ерөнхий нягтлан бодогч нар хандах эрхтэй / хөрөнгө оруулалтын удирдлагын системийн ашиглалт, хяналтын үйл явц хангалтгүй байгааг харуулж байна.

1.3.5 Аудитын явцад 2020-2021 он дамжин УТХО-ын санхүүжилтээр хэрэгжих 16,393.9 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээний санхүүжилтийг он тус бүрээр хуваарилсан байдлыг тулган баталгаажуулахад төлөвлөлтийн зарчмыг хангаагүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай нь уялдуулаагүйгээс 2020 оны санхүүжилтийг 5,177.8 сая төгрөгөөр дутуу төлөвлөж, баталсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.3.5³³ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 /сая төгрөгөөр/

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Батлагдсан		Төсвийн тухай хуулиар 2020 онд хуваарилах санхүүжилт	Зөрүү
			Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн		
1	X.1.1.10	Хүүхэд залуучуудын парк /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2020	2021	1,500.0	238.2	750.0	511.8
2	XI.1.86	Орон сууцны дулааны шугам сүлжээ, 60 айл /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон, 6 дугаар баг/	2020	2021	150.0	50.0	75.0	25.0
3	XI.1.128	Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон /	2020	2021	450.0	100.0	225.0	125.0
4	XI.1.148	Цэвэр усны шугам /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Хонгор морьт, 1 дүгээр баг/	2020	2021	400.0	100.0	200.0	100.0
5	XI.2.15	Нийтийн эзэмшлийн байруудын инженерийн шугам сүлжээний засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон баг, 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар байр/	2020	2021	430.0	80.0	215.0	135.0
6	XII.1.1.289	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Ерөө сум/	2020	2021	2,100.0	401.0	1,050.0	649.0
7	XII.1.2.30	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Хүдэр сум/	2020	2021	500.0	100.0	250.0	150.0
8	XII.1.2.83	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	2020	2021	209.7	100.0	104.9	4.8
9	XII.1.2.84	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 3 дугаар цэцэрлэг, "А" байр/	2020	2021	441.0	100.0	220.5	120.5
10	XII.2.2.2	Мөнгөнхараа чуулгын байрын их засвар, тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Мандал сум/	2020	2021	1,200.0	500.0	600.0	100.0

³³ ... хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.5 шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

11	XII.2.2.15	Соёлын төвийн барилгын их засвар /Сэлэнгэ, Жавхлант сум/	2020	2021	385.0	100.0	192.5	92.5
12	XIII.1.1.78	Хүдэрийн замаас Ерөө хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.7 км /Сэлэнгэ, Ерөө сум/	2020	2021	2,500.0	1,000.0	1,250.0	250.0
13	XIII.2.1.13	Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/	2020	2021	5,500.0	50.0	2,750.0	2,700.0
14	XIII.2.1.21	Хяраан голын гүүр /Сэлэнгэ, Алтанбулаг сум, 3 дугаар баг/	2020	2021	344.0	50.0	172.0	122.0
15	XVII.1.70	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор /Сэлэнгэ, Жавхлант сум/	2020	2021	284.2	50.0	142.1	92.1
НИЙТ ДҮН					16,393.9	3,019.2	8,197.0	5,177.8

1.3.6 УТХО-ын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын бус урсгал зардал, урсгал засварын шинж чанартай дараах төсөл, арга хэмжээг тусган баталсан нь Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зориулалттай “Шинэ хөдөө” төсөл буюу хээлтүүлэгч бух, хүлэмж, 6 төрлийн хүнсний ногооны үр /төмс, лууван, шар болон хүрэн манжин, сонгино, саримс /, ногоон тэжээл худалдан авах төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг 500.0 сая төгрөг,
- Ахмадын байрны их засвар/ Сэлэнгэ Алтанбулаг сум /, төсөвт өртөг 28.0 сая төгрөг,
- Ахмадын байрны их засвар/ Сэлэнгэ Шаамар сум, Дулаанхан тосгон /, төсөвт өртөг 10.0 сая төгрөг,
- Ахмадын байрны их засвар, тоног төхөөрөмж / Сэлэнгэ Жавхлант сум /, төсөвт өртөг 10.0 сая төгрөг,
- Сайхан сумын 4 дүгээр сургуульд тавилга худалдан авах, төсөвт өртөг нь 18.0 сая төгрөг гэх мэт.

1.3.7 Дээрх байдлаас үндэслэн УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж баталсан төсөл, арга хэмжээнүүд нь төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна гэж дүгнэж байна.

2.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?

“Инженерийн шугам сүлжээ”-г худалдан авах ажиллагаанд Билиг ДБ сургуульд чиглэсэн шалгуурыг тусгасан нь худалдан авах ажиллагааны өрсөлдөх тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй байх үндсэн зарчмыг алдагдуулсан байна.

2.1.1 УТХО-ын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13³⁵-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд шилжүүлэхээр

³⁵ Захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

зохицуулагдсан бөгөөд 2020 оны Төсвийн тухай хуулиар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан байна.

2.1.2 УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний эрхийг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн дотор шилжүүлэх ёстой атал БСШУС болон ЗТХ-ийн сайд нар 31 төсөл, арга хэмжээний эрхийг 2 дугаар сард, 1 төсөл, арга хэмжээний эрхийг 3 дугаар сард буюу 22-61 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./ Үүнийг тодруулбал:


- БСШУС-ын сайд 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 1а/734 дүгээр тушаалаар 7,788.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27, 02 дугаар сарын 21-ний өдрийн А/96 дугаар тушаалаар 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний эрх,
- ЗТХ-ийн сайд 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар 2,874.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ, 3 дугаар сарын 16-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар 5,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна.

2.1.3 Тайлант онд хэрэгжүүлэхээр батлагдсан зарим төсөл, арга хэмжээний эрхийг журамд заасан хугацаанаас хэтрүүлэн шилжүүлж байгаа нь худалдан авах ажиллагааны хугацаа оройтох, гүйцэтгэл нь чанарын шаардлага хангахгүй байх, улмаар хууль, журам зөрчигдөх эрсдэлийг үүсгэж байна.

2.1.4 Захиалагч аймгийн ЗДТГ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан ТБОНӨХБАҮХА ажиллагаанд мөрдөх босго үнийн дагуу эрх шилжсэн, шинээр эхлэх 53 төсөл, арга хэмжээнээс / шинээр эхлэх 61 төсөл арга хэмжээнээс өмнөх оноос шилжсэн 6, БХБ-ын сайдын багцад худалдан авах ажиллагаа нь зарлагдсан Баруунбүрэн сумын ЗДТГ-ын барилга, огт хэрэгжээгүй Алтанбулаг сумын нийтийн бие засах байрны төсөл арга хэмжээг хассан дүн / 30 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 20 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шууд худалдан авах аргаар сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

2.1.5 Үүнээс 30 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар зохион байгуулах “Үнэлгээний хороо”-г аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 20 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Ажлын хэсэг”-ийг аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

2.1.6 Сангийн сайдын 2015 оны 330 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”- т “Үнэлгээний хороо”, “Ажлын хэсэг”-т томилогдсон 245 гишүүний 80.8 хувь буюу 198 хүний овог нэр бичигдээгүй, гарын үсэг зурагдаж, баталгаажуулаагүй зэргээр хүчин төгөлдөр бус байна. Үүнийг графикаар үзүүлбэл:



Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

2.1.7 Захиалагч аймгийн ЗДТГ нь худалдан авах ажиллагааны “Үнэлгээний хороо”, “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд аймгийн ИТХ-аас томилсон иргэнийг бус тухайн иргэнтэй тохиролцсоны үндсэн дээр гишүүнээр томилсон байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4³⁶ дэх заалтыг зөрчсөн байна.

2.1.8 Үнэлгээний хороо болон ажлын хэсэгт томилогдсон нийт 245 гишүүнээс 24 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1³⁷ дэх заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 7-д харуулав./

2.1.9 Үнэлгээний хороо нь УТХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг “Тендерийн жишиг баримт, бичиг”-ийн дагуу боловсруулах ёстой атал 633.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Инженерийн шугам сүлжээ худалдан авах /Сэлэнгэ, Мандал сум, 6 дугаар баг/ төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод “Магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх” гэсэн шаардлагыг тусгалгүйгээр буюу гүйцэтгэгчээр шалгаруулсан Билиг ДБ дунд сургуульд чиглэсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 19.2³⁸ дахь заалтыг зөрчсөн байна.

2.1.10 2020 оны Төсвийн тухай хууль батлагдахаас өмнө ашиглалтад орсон /2014 онд / дээрх шугам сүлжээг төрд худалдан авахаар буюу Билиг ДБ сургуульд зориулан УТХО-ын төлөвлөгөөнд тусган, төсөвт өртгөөр худалдах үнийн саналаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6.1³⁹-д заасан худалдан авах ажиллагаанд өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй байх үндсэн зарчмыг алдагдуулсан байна.

2.1.11 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох НТШ-ыг 2 удаа зохион байгуулж, нэг ч оролцогч санал ирүүлээгүй гэх үндэслэлээр дараах 8 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчидтэй шууд гэрээ байгуулсан боловч захиалагч аймгийн ЗДТГ нь гэрээний хувь болон уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Сангийн яаманд хүргүүлээгүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.3⁴⁰ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- 5,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/,
- 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Хүдэр сум/,

³⁶ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

³⁷ Энэ хуулийн 23.8-д заасан журмын дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

³⁸ Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

³⁹ Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

⁴⁰ Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

- 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө” төсөл /Сэлэнгэ/,
- 441.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 3 дугаар цэцэрлэг, “А” байр/,
- 430.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн байруудын инженерийн шугам сүлжээний засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон баг 1-13 дугаар байр /”,
- 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэвэр усны шугам /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Хонгор морьт, 1 дүгээр баг/,
- 344.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хяраан голын гүүр /Сэлэнгэ, Алтанбулаг сум, 3 дугаар баг/,
- 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон сууцны дулааны шугам сүлжээ, 60 айл /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон 6 дугаар баг/

2.1.12 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу 2020 оны бүх худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд оруулсан байна.

2.1.13 Аймгийн ОНӨГ нь тайлант онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1⁴²-д заасны дагуу тайлагнаж, хагас жилийн тайланг 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 369 дүгээр, жилийн эцсийн тайланг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 27 дугаар албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн байна.

2.1.14 Өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй байх үндсэн зарчмыг алдагдуулахаар батлагдсан 633.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Инженерийн шугам сүлжээ худалдан авах /Сэлэнгэ, Мандал сум, 6 дугаар баг/ төсөл, арга хэмжээнээс бусад худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.

2.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулсан уу?

Тайлант онд 5 төсөл, арга хэмжээ гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй байна.

2.2.1 Аймгийн Засаг даргад 2020 оны УТХО-аар он дамжсан 6, шинээр эхлэх 55 зэрэг нийт 61 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн бөгөөд шинээр эхлэх 59 төсөл, арга хэмжээ / Зураг, төсөв хийгдээгүйгээс ХАА-г зохион байгуулаагүй 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алтанбулаг сумын Нийтийн бие засах газар , ХАА-г зохион байгуулсан боловч гүйцэтгэгчээр шалгарсан компани гэрээ байгуулаагүй 28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүдэр сумын цэцэрлэгийн тоног төхөөрөмж зэрэг 2 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулаагүй./-нд 55,228.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

⁴² Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах хугацаанд ирүүлнэ. 3.1.1.Хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор, 3.1.2.Бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

2.2.2 Үүнээс тайлант онд шинээр эхэлсэн 53 төсөл, арга хэмжээнд 21,773.5 сая төгрөгийн гэрээ байгуулснаас 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэвэр усны шугам /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Хонгор морьт 1 дүгээр баг”, 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Түшиг сум/” 2 төсөл, арга хэмжээний тайлант оны санхүүжилт 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн төсвийн тодотголоор хасагдсан тул уг төсөл, арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.

2.2.3 Ингэснээр 51 төсөл, арга хэмжээнээс 36 нь / 15 төсөл, арга хэмжээ 2021 онд дуусна./ тайлант онд бүрэн хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан ч гүйцэтгэгч компаниас тавьсан хүсэлтийн дагуу захиалагч аймгийн ЗДТГ нийт 1,171.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 3 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 2021 он дамжин хэрэгжихээр сунгасан байна.Үүнийг тодруулбал:

- 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Засаг даргын Тамгын газрын барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/ төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 2021 оны 09 дүгээр сарын 01,
- 453.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл тосгон/ төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 01,
- 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 4-р сургуульд тавилга худалдан авах төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 2021 оны 03 дугаар сарын 08 хүртэл сунгасан байна.

2.2.4 Дээрхээс бусад 33 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусахаас захиалагч аймгийн ЗДТГ нь 10.0 сая төгрөгийн өртөг бүхий “Худаг /Сэлэнгэ, Жавхлант сум, Цагаан даваа/” төсөл, арга хэмжээний зураг, төсвийг хийлгээгүйгээс хэрэгжээгүй, 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Сайхан сум/” төсөл, арга хэмжээний зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүйгээс хэрэгжсэн боловч улсын комисс хүлээж аваагүй байна.

2.2.5 Тайлант онд гүйцэтгэгчээс шалтгаалж 656.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 3 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнд:

- 257.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, Янзагахан цэцэрлэг / гэрээний хугацаа 2020 оны 09 дүгээр сарын 15,
- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум/ төсөл, арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 01,
- 199.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг / гэрээний хугацаа 2020 оны 10 дугаар сарын 11 хүртэл.

2.2.6 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зориулалттай, 500.0 сая төгрөгийн өртөг бүхий “Шинэ хөдөө” төслийн хүрээнд Газар агро компаниас 50 ширхэг хээлтүүлэгч бух, Мөнх ногоон тал компаниас 80 ширхэг хүлэмж, Хайтан цагаан чөлөөт бүс компаниас нийт 85.5 тн ногоон тэжээл, овьёос, судан өвс худалдан авч актаар баталгаажуулсан хэдий ч бух нь нийлүүлэгч компанийн эзэмшилд байгаа, хүлэмж,

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг ногоон тэжээл нь ХАА-г дэмжих сангийн Сэлэнгэ салбарын агуулахад хадгалагдаж байгаа гэх үндэслэлээр өдийг хүртэл хаана хуваарилах, хэн ашиглах нь ч тодорхой бус байна.

2.2.7 Мөн уг төслийн хүрээнд Элит үр компаниас 38.9 тн хүнсний ногооны үр худалдан авч, 2020 оны хавар 17 суманд хуваарилан тариулсан боловч хэдэн өрхөд хүргэсэн, хэдэн тн ургац хураан авсан, ямар үр дүнд хүрсэн зэргээр үр дүнг тооцоогүй байгаа нь 500.0 сая төгрөгийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг бууруулж байна.

2.2.8 Тайлант онд хэрэгжиж дуусаагүй 5 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 171.3 сая төгрөгийг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, санхүүжилтийг 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн бодит гүйцэтгэлээр олгохоор зохицуулсан байна.

2.2.9 Зайлшгүй хийх шаардлагатай нэмэлт ажил гарсан гэх шалтгаанаар “*Нийтийн эзэмшлийн байруудын фасадын засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/*” төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлт болох 36.9 сая төгрөгийг зарцуулахаар зураг, төсөвгүйгээр нэмэлт ажлын гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4⁴³, Барилгын тухай хуулийн 24.1.1⁴⁴ дэх заалтуудыг зөрчсөн байна.

2.2.10 Захиалагч аймгийн ЗДТГ нь тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн гэрээний хуулбар файлыг цахим системд оруулаагүй байгаа нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.6⁴⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

2.2.11 Төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад оруулсны дараа эцсийн санхүүжилтийг олгосон бөгөөд гэрээ дүгнэсэн актаар гэрээний биелэлт, үр дүнг үнэлж, хугацаа хэтрүүлсэн 7 гүйцэтгэгчид 9.1 сая төгрөгийн алданги ногдуулж, 16 төсөл, арга хэмжээнд чанарын баталгааг төсөвт өртгийн 5 хувиар тооцон, 406.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

2.2.12 Дээрхээс үзэхэд тайлант онд гэрээний дагуу ашиглалтад оруулах 39 төсөл, арга хэмжээнээс 34 буюу 87.2 хувийг улсын комиссын актаар хүлээн авсан бөгөөд 5 төсөл, арга хэмжээ / 2.2.4, 2.2.5 –д дурдсан төсөл арга хэмжээнүүд / гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй буюу гэрээний хэрэгжилт 87,2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагджээ.

2.3 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү ?

⁴³ Хөрөнгө оруулалтын төсөвт хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

⁴⁴ батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх;

⁴⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.5-д зааснаар холбогдох гэрээг Сангийн яаманд хүргүүлэхдээ Цахим системд гэрээг бүртгэж, хуулбар файлыг оруулсан байна.

УТХО-ын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

2.3.1 Өмнөх оноос шилжин ирсэн 6, тайлант онд шинээр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын 26 төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4⁵², Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12⁵³-т заасны дагуу байгуулсан гэрээний үндсэн дээр аймгийн ГХБХБГ-аар захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлсэн байна. Тус газрын Барилгын хэлтсийн дарга, инженерүүд нь “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9⁵⁴, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.1⁵⁵-т заасны дагуу үе шат бүрд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, улсын комиссын дарга, гишүүнээр ажиллаж, хяналтын тайлангаар баталгаажуулсан байна.

2.3.2 Барилгын тухай хуулийн 37.1.5⁵⁶, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-3.1.4⁵⁷-т заасны дагуу дээр дурдсан 38 ажилд зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр холбогдох байгууллагуудаар гүйцэтгүүлсэн байна. Зураг, төсөв зохиогчийн хяналтыг БХБ-ын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2.3⁵⁸, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.3⁵⁹-т заасны дагуу төсөл, арга хэмжээний үе шат бүрд хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулан, зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтээр баталгаажуулсан байна.

2.3.3 Барилга угсралт, их засварын ажлаас бусад буюу 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ахмадын байрын их засвар, тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Жавхлант сум/” төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтнээр ахлуулсан ажлын хэсэг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бол 500.0 сая

⁵² 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

⁵³ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

⁵⁴ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

⁵⁵ Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналт тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

⁵⁶ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

⁵⁷ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

⁵⁸ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан гүйцэтгэнэ: 3.2.3 барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

⁵⁹ Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрд зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө төсөл /Сэлэнгэ/” арга хэмжээнд захиалагчийн хяналт хийгдээгүй байна.

2.3.4 УТХО-аар 2020 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд аймгийн ТЭЗ-ийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт огт хийгдээгүй бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 69.1⁶²-дэх заалтыг зөрчсөн байна.

2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр үр дүнтэй байна уу?

Гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 5 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 171.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2.4.1 УТХО-ын санхүүжилтийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 40.3.3⁷⁰, 44.2⁷¹, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.5.6⁷²-д заасны дагуу урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн олгохоор зохицуулсан байдаг.

2.4.2 Өмнөх оноос он дамжсан буюу 80 хувиас дээш гүйцэтгэлтэй “Цэвэрлэх байгууламжийн шинэчлэл /Сэлэнгэ, Ерөө сум, Бугант тосгон /” төсөл, арга хэмжээнд 345.0 сая төгрөг, “Соёл, спортын цогцолборын барилга /Сэлэнгэ, Ерөө сум, Бугант тосгон /” төсөл, арга хэмжээнд 60.3 сая төгрөг зэрэг нийт 405.3 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн олгосон бөгөөд уг төсөл, арга хэмжээнүүд 2020 онд бүрэн хэрэгжиж улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

2.4.3 Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430 дугаар тогтоолын дагуу гэрээний хугацаанд дуусаагүй 1,350.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Татварын хэлтсийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, 850.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Орхонтуул сум, 1 дүгээр сургууль/ зэрэг 2 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 1,451.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

2.4.4 Ингэснээр 850.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Орхонтуул сум, 1 дүгээр сургууль/ төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар ашиглалтад оруулж, үлдэгдэл санхүүжилтийг бүрэн олгосон бол 1,350.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Татварын хэлтсийн барилга /Сэлэнгэ,

⁶² Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ... хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна

⁷⁰ Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана: 40.3.3. урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн хэлбэр

⁷¹ Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө.

⁷² Урьдчилгаа төлбөрийн баталгаа /Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Урьдчилгаа төлбөрийн баталгааны маяг”-ын дагуу гаргана/

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Сүхбаатар сум/ -ыг гүйцэтгэгчээс шалтгаалан ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байна.

2.4.5 Тайлант онд улсын комиссын актаар хүлээн авсан 34 төсөл, арга хэмжээнээс 33 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд бүртгэл, тайланд бүрэн тусгасан бөгөөд ашиглагч байгууллагуудаас гүйцэтгэлийн чанар байдлын талаар гомдол, санал гараагүй байна.

2.4.6 Харин захиалагч аймгийн ЗДТГ нь 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө төсөл /Сэлэнгэ/” арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

2.4.7 Гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 5 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 171.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, санхүүжилтийг 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн бодит гүйцэтгэлээр олгохоор зохицуулсан байна. / 2.2.6 –д тодорхой дурдав /

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **2,265.2** сая төгрөгийн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- ❖ 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнд огт зураг төсөв хийлгэлгүйгээр төлөвлөж, хэрэгжүүлсэн,
- ❖ 1,154.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний зураг төслийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй, /Дээрх 12,726.3 сая төгрөгийн зөрчилд давхардаагүй төсөвт өртгийн дүнгээр тооцсон./
- ❖ 514.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний зураг төсөлд магадлал хийлгэж, баталгаажуулаагүй, /Дээрх 12,726.3 сая төгрөгийн зөрчилд давхардаагүй төсөвт өртгийн дүнгээр тооцсон./
- ❖ “Үнэлгээний хороо, ажлын хэсгийн гишүүнээр ажилласан 198 гишүүний /давхардсан тоогоор / мэдүүлгийг гарын үсгээр баталгаажуулаагүй,
- ❖ Үнэлгээний хороо болон ажлын хэсэгт томилогдсон 24 гишүүн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй,
- ❖ 8 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох НТШ-ыг 2 удаа зохион байгуулж, санал ирээгүй гэх үндэслэлээр шууд гэрээ байгуулсан боловч гэрээний хувь болон уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Сангийн яаманд хүргүүлээгүй,
- ❖ Захиалагч аймгийн ЗДТГ нь тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээний хуулбар файлыг цахим системд оруулаагүй,
- ❖ Зураг, төсөвгүй нэмэлт ажилд тендерийн хэмнэлт 36.9 төгрөгийг зарцуулах гэрээ байгуулсан,
- ❖ 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө төсөл /Сэлэнгэ/” арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ❖ Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн, шинээр эхлэх төсөл арга хэмжээний 67.3 хувь нь “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Сэлэнгэ аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй уялдаагүй байна.
- ❖ УТХО-аар хэрэгжих төсөл, арга хэмжээний эрхийг Сэлэнгэ аймгийн Засаг даргад шилжүүлэхдээ 22-61 хоногоор хугацаа хоцроосон байна.
- ❖ Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 70.9 хувийн зураг, төсвийг төсөв батлагдсанаас хойш гүйцэтгүүлсэн бол зураг, төсвийн 68.9 хувийг магадлал хийлгэж баталгаажуулаагүй байна.
- ❖ 2020-2021 он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн дагуу жигд хуваарилаагүй байна.
- ❖ “Инженерийн шугам сүлжээ”-г худалдан авах ажиллагаанд Билиг ДБ сургуульд чиглэсэн шалгуурыг тусгасан нь худалдан авах ажиллагааны өрсөлдөх тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй байх үндсэн зарчмыг алдагдуулсан байна.
- ❖ “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-т 198 гишүүний / давхардсан тоогоор / овог нэр бичигдээгүй, гарын үсэг зурагдаж баталгаажуулаагүй зэргээр хүчин төгөлдөр бус байна.
- ❖ Үнэлгээний хороо болон ажлын хэсэгт томилогдсон гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүрэн гаргуулаагүй байна.
- ❖ НТШ-д оролцогч санал ирүүлээгүй гэх үндэслэлээр 8 төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулсан боловч гэрээний хувь болон уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Сангийн яаманд хүргүүлээгүй байна.
- ❖ Тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн гэрээний хуулбар файлыг цахим системд оруулаагүй байна.
- ❖ Тайлант онд 5 төсөл, арга хэмжээ гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй бөгөөд үлдэгдэл санхүүжилт 171.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.
- ❖ Гэрээний хугацаа хэтрүүлсэн 7 гүйцэтгэгчид 9.1 сая төгрөгийн алданги ногдуулж, барагдуулсан байна.
- ❖ УТХО-ын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт огт хийгдээгүй байна.
- ❖ 500.0 сая төгрөгийн өртөг бүхий “Шинэ хөдөө” төслийг үр ашигтай хэрэгжүүлээгүй бөгөөд гүйцэтгэлд нь захиалагчийн хяналт хийгдээгүй, бүртгэл тайланд тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргил- д:

- ❖ Төсөл, арга хэмжээг салбарын гол тэргүүлэх чиглэл, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсний үндсэн дээр УТХО-аар хэрэгжүүлэхээр санал хүргүүлэх.
- ❖ Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдсон, инженер-геологийн дүгнэлт гарсан, зураг төсөв нь хийгдэж, магадлалаар баталгаажуулсан зэрэг төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнүүдийг УТХО-д тусгуулах арга хэмжээ авах.
- ❖ 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Шинэ хөдөө” төслийн хүрээнд худалдан авсан хөрөнгийг бүрэн хүлээн авч, хуваарилах, төслийн үр өгөөжийг тооцох.
- ❖ Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч байх.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа-д:

- ❖ “Үнэлгээний хороо”, “Ажлын хэсэг”-т ажиллах гишүүдийн “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг бүрэн гаргуулж, албан тушаалтнуудын овог, нэр, гарын үсгээр баталгаажуулж, архивлах.
- ❖ Зураг төсөв нь урьдчилан хийгдсэн нэмэлт ажилд хөрөнгө зарцуулахаар нэмэлт гэрээ хийж байх.
- ❖ УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд бүрэн тусгаж байх.
- ❖ Хөрөнгө оруулалтын удирдлагын системд ажиллах эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох мэдээллийг бүрэн оруулах.
- ❖ НТШ-д санал ирүүлээгүй гэх үндэслэлээр шууд гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний гэрээний хувь болон уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Сангийн яаманд тухай бүр хүргүүлж байх.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан-д:

- ❖ “Үнэлгээний хороо” болон “Ажлын хэсэг”-т томилогдсон гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүрэн гаргуулж, албан тушаалтнуудын овог, нэр, гарын үсгээр баталгаажуулж, архивлах.
- ❖ Тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн гэрээний хуулбар файлыг цахим системд тухай бүр оруулж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

С.БААСАНСҮРЭН

АУДИТОР

Ж.ЦОГТ

